

САЛБАРЫН ХУНИЙ НӨӨЦ, СУДАЛГААНЫ ХЭЛТСИЙН ЦАХИМ УР ЧАДВАР, ХУНИЙ НӨӨЦИЙН БОДЛОГО  
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН ДЭМБЭРЭЛ ОВОГТОЙ СЭЛЭНГИЙН 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС  
ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэл тийн хувь
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)			
1	2	3	4	5	6	7		

**ЗОРИЛТ 1.” ИННОВАЦ, ГАРААНЫ БИЗНЕС, ИХ ӨГӨГДӨЛ, ХИЙМЭЛ ОЮУН ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧНЫГ  
БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ, БОДЛОГЫН УДИРДАМЖААР ХАНГАНА” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД**

1.	Арга хэмжээ 1.1. Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын дагуу бүсүүдэд, Бүсийн цахим шилжилт, өндөр технологи нэвтрүүлэлт” сэдэвт салбар хуралдааныг зохион байгуулна.	Зохион байгуулсан зөвлөгөөний тоо	-	1	<p>Бүсийн зөвлөлийн өргөтгөсөн хуралдааны үеэр бүсийн цахим шилжилт, өндөр технологи нэвтрүүлэлтийн салбар хуралдааныг яамны эрхлэх асуудлын хүрээнд:</p> <p>1. Салбарын зорилтыг бүсийн хөгжилтэй уялдуулан бүс, орон нутагт хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 5 мега төслийн саналыг хүснэгтийн дагуу боловсруулан 2025 оны 04 дүгээр сарын 24-ны өдрийн 01/941 дугаартай албан бичгээр Монгол Улсын Шадар сайд С.Амарсайханд хүргүүлэв.</p> <p>2. Бүсийн зөвлөлийн өргөтгөсөн хуралдаанд модератор, панилестаар оролцох албан тушаалтуудын нэrsийн жагсаалтыг холбогдох мэдээллийн хамт гарган 2025 оны 04 дүгээр сарын 02-ны өдөр Орон нутаг, салбарын хөгжлийн бодлого, зохицуулалтын газрын мэргэжилтэн Г.Энхболорт хүргүүлэв.</p>	03.10-06.30	100%
----	---	-----------------------------------	---	---	--	-------------	------

				<p>3.Бүсийн зөвлөлийн өргөтгөсөн хуралдаанд модератор, панелистаар оролцох албан тушаалтнууд болон хуралдаан зохион байгуулах ажлын хэсэг, хурлын протокол хөтлөх албан хаагчдад зааварчилгаа өгөх, хурлын агуулга, чиглүүлэх асуулт тохирох нэгдсэн уулзалтад оролцов. Уулзалт 2025 оны 04 дүгээр сарын 04-ны өдөр Блуу Скай зочид буудлын Эмералд танхимд зохион байгуулагдсан. Тус уулзалтад СБТГ-н ахлах шинжээч Ч.Болор-Эрдэнэ, мэргэжилтэн Д.Сэлэнгэ, ТЦҮЗГ-ын дарга П.Батбаатар, Үйлчилгээний нэгдсэн төвийн зохицуулалтын газрын дарга М.Уранчимэг, МХС ХХК-ийн Стратеги, бизнес хөгжлийн газрын захирал Ц.Одхүү, МЦХ ХХК-ийн Маркетинг, борлуулалтын газрын захирал О.Цолмон, МУИС-Мэдээллийн технологи, электроникийн сургуулийн захирал Б.Ганбат, Харилцаа холбооны зохицуулах хорооны Өргөн нэвтрүүлгийн зохицуулалтын газрын дарга Э.Золбаяр, МТҮП-н төлөөлөл оролцов.</p> <p>4."Бүсийн зөвлөлийн өргөтгөсөн хуралдаан-2025" бүсийн салбар хуралдааны хэлэлцүүлийн агуулгыг загвар хүснэгтийн дагуу боловсруулан ажлын хэсгийн ахлагч Ш.Батзаяатад танилцуулж, бүсчилсэн хөгжлийн бодлогын хэрэгжилтийн газрын Инновац дамжуулалтын хэлтсийн дарга М.Баярт 2025 оны 04 дүгээр сарын 03-ны өдөр хүргүүлэв.</p> <p>5."Хангайн, Хойд, Говийн бүсийн өргөтгөсөн хуралдаанд оролцох албан тушаалтны" томилолтын тушаалыг боловсруулан Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 04 дүгээр сарын 11-ны өдрийн А/86 тушаалаар, 2025 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн А/107 тушаалаар, 2025 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн тушаалаар тус тус батлуулав.</p> <p>6."Говийн болон Төвийн бүсийн хөгжлийг дэмжих зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын тогтоолын төсөлд санал боловсруулан 2025 оны 05 дугаар сарын 19-ны өдрийн 01/1186 дугаартай, 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн 01/1324 дугаартай албан бичгээр Монгол Улсын шадар сайд С.Амарсайханд хүргүүлэв.</p>	
--	--	--	--	--	--

**ЗОРИЛТ 2. “ХАРИЛЦАА ХОЛБОО, МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН САЛБАРЫН ХҮНИЙ НӨӨЦИЙН ХӨГЖИЛ, ТОГТВОРТОЙ ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ, ХҮНИЙ НӨӨЦИЙН БОДЛОГО БОЛОВСРУУЛАХ, ТӨЛӨВЛӨЛТ ХИЙНЭ” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД**

2.	Арга хэмжээ 2.1. Бүх нийтийн цахим ур чадвар, чадамжийг дээшлүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг шинэчлэн боловсруулан батлуулах.	Батлуулсан баримт бичгийн too	БНЦУЧ ЧД арга хэмжээний төлөвлөгөө 2022-2026	1	Тайлант хугацаа болоогүй	07.01-12.12	-
3.	Арга хэмжээ 2.2. Төрийн албан хаагчдын цахим ур чадварыг дээшлүүлэх сургалтын хөтөлбөр боловсруулан батлуулах	Батлуулсан баримт бичгийн too	-	1	Тайлант хугацаа болоогүй	07.01-12.12	-
	Арга хэмжээ 2.3. Харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарын хүний нөөцийн бодлогын баримтлах чиглэл боловсруулах батлуулах, ИДС-дын удирдлагуудтай уулзалт зохион байгуулах, санал авах.	Батлуулсан баримт бичгийн too  Арга хэмжээний too	-	1	Батлуулсан баримт бичгийн too -1  Арга хэмжээний too -1	01.02-09.30	
4.	Дэд арга хэмжээ 2.3.1 Харилцаа холбоо мэдээлэл технологийн чиглэлээр сургалтын үйл ажиллагаа явуулж буй удирдлагуудтай хамтарсан уулзалтыг зохион байгуулах, санал солилцох.	Арга хэмжээний too	-	1	1. Харилцаа холбоо, мэдээллийн технологийн чиглэлээр сургалтын үйл ажиллагаа эрхлэн явуулж байгаа их дээд сургуулиудын удирдлагуудтай хамтран ажиллах, санал солилцох уулзалтыг зохион байгуулахаар 2025 оны 03/127 дугаартай албан бичгээр 23 их дээд сургууль руу албан бичгээр хүргүүлэв.  2. Салбарын хүний нөөцийг сургахад тулгамдаж буй асуудал, тус яамнаас авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар танилцуулж, их дээд сургуулиудын удирдлагууд болон багш нарын төлөөллүүдтэй санал	01.01-06.30	100%

					<p>солилцох уулзалтыг зохион байгуулав. Уулзалтад Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч П.Алтан-Од, Стратеги, бодлого, төлөвлөлтийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ш.Батзаяат, Кибер аюулгүй байдлын бодлого зохицуулалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Пүрэвням, Стратеги, бодлого, төлөвлөлтийн мэргэжилтэн Д.Сэлэнгэ болон их дээд сургуулиудын төлөөллүүд оролцов. Уулзалтыг 2025 оны 01 дүгээр сарын 29-ний өдөр тус яамны Хүндэтгэлийн танхимд зохион байгуулсан.</p> <p>3. Хөгжлийн тэргүүлэх болон эрэлттэй мэргэжлийн чиглэл шинэчлэн батлах” тухай Засгийн газрын тогтоолын төсөлд санал боловсруулан 2025 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн 01/858 дугаартай албан бичгээр Боловсролын яаманд хургуулэв.</p>	
Дэд арга хэмжээ 2.3.2. Харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарын хүний нөөцийн бодлогын баримтлах чиглэлд тусгах саналыг боловсруулан холбогдох байгууллагуудад хүргүүлж саналыг авч нэгтгэн боловсруулах	Саналын тоо	-	1	<p>БЯ, ИДС, УА, ТАХ болон бусад холбогдох байгууллагуудаас саналыг авч нэгтгэсэн байна.</p> <p>Тайлант хугацаа болоогүй</p>	07.01-09.30	-
Арга хэмжээ 2.4. Төрийн үйлчилгээг цахимаар авахад иргэдэд тулгарч буй хүндрэл бэрхшээл, иргэдийн цахим, ур чадварыг тодорхойлох судалгаа хийх, зөвлөмж боловсруулах.	Судалгааны ажлыг хүлээн авч гэрээг дүгнэсэн байна. Батлагдсан баримт бичгийн тоо	-	1	<p>Судалгааны ажлыг хүлээн авч гэрээг дүгнэсэн байна. 1</p> <p>Батлагдсан баримт бичгийн тоо-1</p>	03.03-12.12	

5.	Дэд арга хэмжээ 2.4.1. Төрийн үйлчилгээг цахимаар авахад иргэдэд тулгарч буй хүндрэл бэрхшээл, иргэдийн цахим ур чадварыг тодорхойлох ажлын даалгаврыг боловсруулан батлуулах.	Батлагдсан баримт бичгийн тоо	-	1	1. "Төрийн үйлчилгээг цахимаар авахад иргэдэд тулгарч буй хүндрэл бэрхшээл, иргэдийн цахим ур чадварыг тодорхойлох ажлын даалгаврыг боловсруулан Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 04 дүгээр сарын 02-ны өдөр батлуулав. 2. "Төрийн үйлчилгээг цахимаар худалдан авахад иргэдэд тулгарч буй хүндрэл бэрхшээл, иргэдийн цахим ур чадварыг тодорхойлох судалгаа хийх, зөвлөмж боловсруулах ажлын даалгаврыг боловсруулах" тендэр шалгаруулалтыг зохион байгуулах үүрэг бүхий "Үнэлгээний хороо байгуулах, зардал гаргах тухай" тушаалын төслийг боловсруулж Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн А/118 тушаалаар батлуулав.	03.03-05.30	100%
	Дэд арга хэмжээ 2.4.2. Төрийн үйлчилгээг цахимаар авахад иргэдэд тулгарч буй хүндрэл бэрхшээл, иргэдийн цахим ур чадварыг тодорхойлох судалгаа хийх, зөвлөмж боловсруулах.	Судалгааны ажлыг хүлээн авч гэрээг дүгнэсэн байна.	-	1	Тендэр зарлагдсан.  Тайлант хугацаа болоогүй	06.12-12.12	-
	Арга хэмжээ 2.5. МХХТ-ийн салбарын мэргэжилтэн бэлтгэх салбар зөвлөлийн бүрэлдэхүүн, дүрэм журмыг шинэчлэн батлуулах, салбар зөвлөлийн хуралдааныг зохион байгуулах, "Мэргэшсэн болон зөвлөх инженерийн" зэрэг олгох шалгалтын комисст ажиллах, батламж гардуулах үйл ажиллагааг зохион байгуулах	Батлагдсан баримт бичгийн тоо  Арга хэмжээний тоо	-	1	Батлагдсан баримт бичгийн тоо-1  Арга хэмжээний тоо -1	01.02 - 12.12	

	Дэд арга хэмжээ 2.5.1. “Мэргэшсэн болон зөвлөх инженерийн” зэрэг олгох шалгалтын комисст ажиллах, батламж гардуулах үйл ажиллагааг зохион байгуулах	Арга хэмжээний тоо	-	1	Мэргэшсэн болон зөвлөх инженерийн шалгалтын комисст орж ажилласан. Харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарын мэргэжилтэнд мэргэжлийн зэрэг олгох шаардлага, болзлыг хангасан нэр бүхий горилогчдод “Зөвлөх инженер”-дэд гэрчилгээ, хувийн тэмдэг олгох үйл ажиллагааг яамны хүндэтгэлийн танхимд зохион байгуулсан.	01.02-02.10	100
6.	Дэд арга хэмжээ 2.5.2. МХХТ-ийн салбарын мэргэжилтэн бэлтгэх салбар зөвлөлийн бүрэлдэхүүн, дүрэм журмыг шинэчлэн батлуулах, салбар зөвлөлийн хуралдааныг зохион байгуулах.	Батлагдсан баримт бичгийн тоо	-	1	Тайлант хугацаа болоогүй	08.04-12.12	-
7.	Арга хэмжээ 2.6 Их дээд сургуулиудад суралцаж буй оюутнуудыг дадлага хийхэд дэмжлэг үзүүлэх, хамтран ажиллана.	Хамтран ажилласан байгууллагын тоо	-	3	<ol style="list-style-type: none"> <li>Мэдээлэл технологийн чиглэлээр III-IV курст суралцаж буй оюутнуудыг харьяа болон салбарын байгууллагуудад мэргэжлийн чиглэлээр дадлага хийлгэх тал дээр хамтран ажиллахаар 2025 оны 02 дугаар сарын 14-ны өдрийн 01/357 дугаартай албан бичгээр 23 их дээд сургуулиудад хүргүүлэв.</li> <li>Их дээд сургуулиудын ХХМТ-ийн чиглэлээр суралцаж буй III-IV курсын оюутнуудыг дадлагад гаргахаар ирүүлсэн саналыг үндэслэн 2025 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн 01/1161 дугаартай албан бичгээр дадлагад гарах оюутнуудын нэrsийн жагсаалтын хамт гарган харьяа болон салбарын байгууллагын дарга нарт хүргүүлэв.</li> <li>Үндэсний Батлан хамгаалах их сургууль, ШУТИС-МХТС, МУИС, Отгонтэнгэр их сургуулийн оюутнуудын дадлагын ажлыг эхлүүлээд байна.</li> </ol>	02.10-07.30	100%

**ЗОРИЛТ 3. “ ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧИЙН НИЙТЛЭГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛАХ” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД**

8.	Арга хэмжээ 3.1.TAX-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг холбогдох журамд заасан хугацаанд боловсруулж батлуулах, тайлагнах.	Батлуулсан баримт бичгийн тоо	-	1	Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж газрын даргаар батлуулсан. Өөрийн болон нэгжийн гүйцэтгэлийн тайланг хугацаанд нь гарган тайлагнасан.	01.10-12.12	100%
9.	Арга хэмжээ 3.2.Чиг үүргийн дагуу төлөвлөгөөний биелэлт, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт болон шаардлагатай бусад тоо баримт, мэдээллийг тогтоосон хугацаанд нь чанартай гаргаж, холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлэх.	Хүргэсэн биелэлтийн тоо	-	Биелэл тийг гаргаж хүргүүл сэн байна.	1. ЦХИХХ сайдын 2025 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн А/43 дугаар сайдын тушаалаар “Бүсийн цахим шилжилт, өндөр технологи нэвтрүүлэлт” сэдэвт салбар хуралдааныг зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсгийг хэрэгжилтийн тайланг бэлтгэн боловсруулж Яамны болон харьяа байгууллагуудын үйл ажиллагааны хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан ахлах мэргэжилтэн Б.Мөнхбатад хүргүүлэв. 2. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн биелэлтийг 2025 оны 05 дүгээр сарын 13-ны өдөр гарган Тогтоол, шийдвэрийн биелэлт, мэдээллийн ил тод байдлын асуудал хариуцсан шинжээч Д.Мөнхсарнайд хүргүүлэв.	01.10-12.12	100%
10	Арга хэмжээ 3.3. Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль болон холбогдох журамд заасны дагуу хөтлөх нэрийн жагсаалтад заасан баримт бичгийг хугацаанд архивлах.	Архивлах баримт бичгийн тоо	-	1	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах, харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарын орон тооны бус дэд зөвлөлийн үйл ажиллагааны баримтыг холбогдох журамд заасны дагуу архивлан 2025 оны 06 дүгээр сарын 10-ны өдөр Архив-бичиг хэргийн мэргэжилтэнд М.Мөнзаяад хүлээлгэн өгөв.	01.10-12.12	100%
11.	Арга хэмжээ 3.4. Авлигын эсрэг хууль, Нийтийн албанад нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон эдгээртэй нийцүүлэн	ХАСХОМ мэдүүлэгийг гаргасан байна.	-	Тухай бүр	Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг зааврын дагуу гарган 2025 оны 02 дугаар сарын 15-ны дотор баталгаажуулсан.	01.10-12.12	100%

	гаргасан хууль тогтоомжийг хэрэгжүүлэх.							
12.	Арга хэмжээ 3.5 Удирдлагаас өгсөн Үүрэг даалгаврыг заасан хугацаанд нь, чанартай гүйцэтгэх, холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлэх.	Шийдвэрлэсэ н албан бичгийн тоо	-	Тухай бүр	Тайлант хугацаанд нийт 89 албан бичиг хугацаанд нь шийдвэрлэж, 80 бичиг боловсруулан илгээсэн.	01.10-12.12	100%	

**Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт**

Д/д	Үүрэг даалгавар (арга хэмжээ)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлт ийн хувь
1.	Үүрэг даалгавар 1. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах дэд зөвлөлийн үйл ажиллагааны сонсгол зохион байгуулах.	Арга хэмжээний тоо	-	1	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах дэд зөвлөлийн үйл ажиллагааны сонсгол зохион байгуулах үйл ажиллагааны тайлан болон танилцуулгыг бэлтгэн Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах зөвлөлийн дэд дарга Д.Гэрэлд хүргүүлэв. Сонсгол зохион байгуулах үйл ажиллагаанд харьяа салбарын байгууллагуудын удирдах албан тушаалтнууд болон ГБХНЯ, ХБХХЕГ, ХБХЭХЗ-ийн гишүүд, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхийн холбооны тэргүүн, Сонсголын бэрхшээлтэй иргэдийн байгууллагуудын иргэний нийгмийн төлөөлөл, Дохионы хэлний хэлмэрч болон Дэд зөвлөлийн гишүүдийн бүрэлдэхүүнтэй сонсголыг 2025 оны 01 дүгээр сарын 09-ны өдөр тус яамны хүндэтгэлийн танхимд зохион байгуулав. Сонсголыг mass.mn цахим хуудсаар шууд дамжуулагдсан.	01.02-01.09	100%
2.	Үүрэг даалгавар 2. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарын орон тооны бус дэд зөвлөлийн 2025 оны төлөвлөгөөний төсөлд санал авахаар 2025 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн 02/888 дугаартай албан бичгээр харьяа, салбарын байгууллагын дарга наарт хүргүүлэв.	Батлагдсан баримт бичгийн тоо Батлагдсан төлөвлөгөөн ий тоо	- 1	1	1. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарын орон тооны бус дэд зөвлөлийн 2025 оны төлөвлөгөөний төсөлд санал авахаар 2025 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн 02/888 дугаартай албан бичгээр харьяа, салбарын байгууллагын дарга наарт хүргүүлэв.	05.01-05.30	100%

	зөвлөлийн бүрэлдэхүүн болон 2025 үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан батлуулах				2. 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний төсөлд И-Монгол академи УТҮГ, Мэдээлэл холбооны сүлжээ ХХК, Монголын цахилгаан холбоо ХХК, Үндэсний дата төв УТҮГ, Радио телевизийн үндсэний сүлжээ УТҮГ, Харилцаа холбооны зохицуулах хороо саналаа ирүүлснийг төлөвлөгөөнд тусган Төрийн нарийн бичгийн даргаар 2025 оны 05 дугаар сарын 22-ны өдөр батлуулж, ТЗҮГ-ын Хүний эрх, жендерийн эрх тэгш байдал, хөгжлийн бэрхшээлтэй иргэний асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн Б.Батцэцэгт хүргүүлэв. 3. ЦХИХХ-ны сайдын 2025 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн А/83 дугаар тушаалаар "Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарын орон тооны бус дэд зөвлөлийн" бүрэлдэхүүнийг шинэчлэн батлуулж ТЗҮГ-ын Хүний эрх, жендерийн эрх тэгш байдал, хөгжлийн бэрхшээлтэй иргэний асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн Б.Батцэцэгт хүргүүлэв.		
3.	Үүрэг даалгавар 3. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах Үндэсний чуулга уулзалтад оролцох	Арга хэмжээний тоо	-	1	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах үндэсний зөвлөлийн 2024 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг танилцуулах, ХБХЭХЗ-ийн гишүүдийн зургаан яамны дэд зөвлөлд хийсэн сонсголоос гарсан дүгнэлт, зөвлөмж албан даалгавар, 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний төслийг танилцуулах уулзалтад Стратеги, бодлого, төлөвлөлтийн газрын мэргэжилтэн Д.Сэлэнгэ оролцов. Үндэсний чуулганы уулзалт 2025 оны 02 дугаар сарын 13-нд Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын хурлын танхимд зохион байгуулагдсан.	02.13	100%
4.	Үүрэг даалгавар 4. МУИС-ын Мэдээлэл технологи, электроникийн сургуулиас зохион байгуулж буй Оюутны программчлалын Азийн бүсийн олимпиад зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх	Арга хэмжээний тоо	-	Тухай бүр	МУИС-ын Мэдээлэл технологи, электроникийн сургуулиас зохион байгуулж буй Оюутны программчлалын Азийн бүсийн олимпиад зохион байгуулах талаар яамнаас дэмжлэг үзүүлэх, олимпиадын зохион байгуулалтын талаар санал солилцох уулзалтыг зохион байгуулав. Уулзалтад СБТГ-ын дарга Ш.Батзаяат, мэргэжилтэн Д.Сэлэнгэ, олимпиадыг зохион байгуулах комиссын багын ахлагч багш Г.Багаболд нар уулзвав. Тус олимпиадын хаалтын үйл ажиллагаанд Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч П.Алтан-Од, Стратеги, бодлого,	01.10-06.10	100%

					төлөвлөлтийн газрын мэргэжилтэн Д.Сэлэнгэ нар оролцож тэргүүн байр эзэлсэн баг хамт олонд сайдын гарын бэлгийг гардуулав. Тус олимпиадын хаалтын үйл ажиллагаа 2025 оны 05 дугаар сарын 19-ны өдөр Монгол Улсын Их сургуулийн 1 байрны дугуй зааланд зохион байгуулагдсан		
5.	Үүрэг даалгавар 5. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн сан, Боловсролын яамтай хамtran хэрэгжүүлж буй ОНЦМА төслийн ажлын хэсэгт ажиллах	Arga хэмжээний тоо	-	1	<p>1. Гига санаачилгын хүрээнд НҮБ-ын Хүүхдийн Сангийн санхүүжилтээр Боловсролын яам, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны удирдлага зохион байгуулалтын хүрээнд Боловсролын ерөнхий газар, аймаг нийслэлийн Боловсролын газар, Боловсролын мэдээллийн технологийн төв, Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газар хамtran Олон нийтийн цахим мэдээллийн ажилтан (ОНЦМА), Өсвөрийн Цахим Манлайлагч бэлтгэх төслийн хэрэгжилтийг хангах ажлын хэсгийн хуралдаан оролцож, төслийн хаалтын үйл ажиллагааг зохион байгуулах талаар харилцан санал солилцов. Тус ажлын хэсгийн хуралдаанд мэргэжилтэн Д.Сэлэнгэ оролцов. Хуралдаан 2025 оны 03 дугаар сарын 25-ны өдөр Боловсролын яамны хурлын танхимд зохион байгуулагдсан.</p> <p>2. Олон нийтийн цахим мэдээллийн ажилтан бэлтгэх туршилтын төслийн ажлын хэсгийн хурал 2025 оны 04 дүгээр сарын 10-ны өдөр Боловсролын яамны 111 тоот хурлын танхимд хуралдаж, төслийн хаалтын үйл ажиллагааны төлөвлөгөө болон хөтөлбөрийн талаар ярилцаж санал солилцов.</p> <p>3. Олон нийтийн цахим мэдээллийн ажилтан бэлтгэх туршилтын төслийн хаалтын үйл ажиллагааны арга хэмжээний үеэр сайдын зөвлөх М.Тулгатын хэлэх нээлтийн үгийг бэлтгэн бодлогын дээмжлэг үзүүлэн оролцов.</p> <p>4. Гига санаачилгын хүрээнд НҮБ-ын Хүүхдийн Сангийн санхүүжилтээр Боловсролын яам, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны удирдлага зохион байгуулалтын хүрээнд Боловсролын ерөнхий газар, аймаг нийслэлийн Боловсролын газар, Боловсролын мэдээллийн технологийн төв, Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газруудтай хамtran Олон нийтийн цахим</p>	01.10-04.30	100%

						мэдээллийн ажилтан (ОНЦМА), Өсвөрийн Цахим Манлайлагч бэлтгэх туршилтын төслийн хаалтын үйл ажиллагаа Улаанбаатар зочид буудлын Их танхимд 2025 оны 04 дүгээр сарын 24-ны өдөр зохион байгуулагдав. Тус хаалтын үйл ажиллагаанд Сайдын зөвлөх М.Тулгат, Стратеги, Бодлого, төлөвлөлтийн газрын мэргэжилтэн Д.Сэлэнгэ, Салбар дундын зохицуулалт хариуцсан шинжээч Г.Энхтулга нар оролцов.		
6.	Үүрэг даалгавар 6. Ухаалаг засаг-2 төслийн хүрээнд хэрэгжүүлсэн Ахмад настай иргэдэд цахим ур чадвар олгох төслийн хүрээнд	Арга хэмжээний тоо	-	1	1. Ухаалаг засаг-2 төслийн хүрээнд хэрэгжүүлсэн "Ахмад настай иргэдийн цахим ур чадвар олгох" сургалтын хаалтын үйл ажиллагааны зохион байгуулалтын талаар төслийн багийнхантай уулзалт зохион байгуулсан. Сургалтын үйл ажиллагааны тайлантай танилцаж, хаалтын үйл ажиллагааны хөтөлбөр болон батламж дээр санал солилцов. Тус уулзалтад Төрийн нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч П.Алтан-Од, төсөл хөтөлбөр хариуцсан ахлах мэргэжилтэн Э.Болормаа, Бодлого, төлөвлөлтийн газрын мэргэжилтэн Д.Сэлэнгэ болон төслийн багийн гишүүд оролцов. Уулзалтыг 2025 оны 01 дүгээр сарын 17-ны өдөр 306 тоот хурлын танхимд зохион байгуулав. 2. Ахмад настай иргэдийн цахим ур чадварыг нэмэгдүүлэх "Үндэсний цахим элч" хөтөлбөрийн хаалтын үйл ажиллагаанд оролцож, хөтөлбөрт хамрагдсан 137 сайн дурын цахим элч наарт батламж гардуулах ёслолын үйл ажиллагаанд оролцов. Хаалтын үйл ажиллагааг 2025 оны 01 дүгээр сарын 21-ны өдөр Улаанбаатар Галлериа төвийн Жуулчин танхимд зохион байгуулсан. 3. Ухаалаг засаг-2 төслийн хүрээнд хэрэгжүүлсэн Ахмад настай иргэдэд цахим ур чадвар олгох төслийн нэгжийн 4-н зөвлөхийн дундын болон эцсийн тайлантай танилцаж, тайланд тусгах саналаа saruul.summit@gmail.com цахим шуудангаар хургуулэв	01.02-01.21	100%	
7.	Үүрэг даалгавар 7. Эцэг эхийн зөвлөлийн хурал зохион байгуулах, үйл ажиллагаанд оролцох	Арга хэмжээний тоо	-	1	Тус яамны эцэг эхийн зөвлөлөөс "Хүүхдийн баяр зохион байгуулах" арга хэмжээг 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдөр зохион байгуулав.	05.01-05.30	100%	

**Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт**

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлт ийн хувь
1	2	3	4	5	6	7	
1.	Арга хэмжээ 2.1 Хариуцсан ажлын чиглэлээр байгууллагаас болон бусад газраас зохион байгуулсан хурал, зөвлөгөөн, хэлэлцүүлэгт оролцох.	Оролцсон арга хэмжээний тоо	-	1	1. Гамшигийн аюулын тухай зарлан мэдээллийн дохиогоор ажиллах дадлага сургуульд 2025 оны 03 дугаар сарын 27-ны өдөр хамрагдсан. 2. Пипл ин Нийд ОУТББ, Фаро фаундэйшн ТББ-с зохион байгуулсан DICE төслийн явц болон төслийн үйл ажиллагаанд оролцогч иргэний нийгмийн байгууллагуудын хэрэгжүүлж буй бичил төслүүдийн танилцуулга болон, санал солилцох уулзалт, хэлэлцүүлэгт оролцов. Уулзалт, хэлэлцүүлэг 2025 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр Улаанбаатар зочид буудлын Сүхбаатар танхимд зохион байгуулагдсан. 3. Сайдын зөвлөх Б.Цээсүрэнгийн "Мэдээллийн технологи, хиймэл оюун ухааны хөгжлийн чиг хандлага" сэдвээр 2025 оны 01 дүгээр	01.30-12.12	100%

					сарын 06-ны өдөр зохион байгуулсан сургалтад хамрагдсан.		
2.	Арга хэмжээ 2.2.Худалдан авах ажиллагааны мэргэшүүлэх А3 сургалтад хамрагдах.	Сургалтын тоо	-	1	Худалдан авах ажиллагааны мэргэшүүлэх А3 сургалтад хамрагдсан. Шалгалтыг 2025 оны 06 дугаар сарын сүүлээр өгөхөөр бүртгүүлсэн.	03.10-06.30	70
3.	Арга хэмжээ 2.3.Төрийн албаны мэргэшүүлэх багц сургалтад хамрагдах	Сургалтад хамрагдсан байна	-	1	Төрийн албаны мэргэшүүлэх багц сургалтад хамрагдах хүсэлтийг Хүний нөөцийн асуудал, дотоод сургалт хариуцсан ахлах шинжээч Э.Анхбаярт мэдэгдсэн. Тайлант хугацаа болоогүй.	06.30-12.12	-

**ТАЙЛАН ГАРГАСАН:**

Цахим ур чадвар, салбарын хүний нөөцийн бодлого хариуцсан мэргэжилтэн  
 ( Албан тушаал )

Д.Сэлэнгэ /   
 ( Нэр, гарын үсэг )

0005 06 10  
 ( Огноо )